


Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр  
сарын 04-ны өдрийн 1/163 дугаар  
албан бичгийн хавсралт



**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ 2024 ОНЫ  
1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,  
ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2024 оны 04 дүгээр сарын 04

Арвайхээр

Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагуудад хандан ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2008 оны “Журам батлах тухай” 44 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан “Иргэдээс аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам”-ыг хэрэгжүүлж ажиллалаа.

Иргэдээс 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагуудад хандаж нийт 3024 мэдэгдэл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна.

Иргэдээс ирүүлсэн мэдэгдэл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан хэлбэрээр нь авч үзвэл: биеэр 1792, цахимаар 636, утсаар 53, албан бичгээр 527, Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс шилжүүлсэн 16 мэдэгдэл, гомдол, санал, хүсэлт ирсэн байна.

Иргэдээс ирүүлсэн нийт 3024 гомдол, хүсэлт, санал мэдэгдлийг төрлөөр нь авч үзвэл: хүсэлт 2893 буюу 95.6 хувь, гомдол 102 буюу 3.3 хувь, санал 18 буюу 0.59 хувь, мэдэгдэл 11 буюу 0.36 хувийг тус тус эзэлж байна.

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар иргэдээс ирүүлсэн 3024 өргөдөл, гомдол, мэдэгдэл, саналаас 2953 буюу 97.6 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна. Мөн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн хүсэлт 3 буюу 0.09 хувь, шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа гомдол, санал, хүсэлт 62 буюу 2.05 хувийг эзэлж байна.

Гомдол, санал, мэдэгдэл, хүсэлтийг шилжүүлж, шийдвэрлүүлсэн байдлаар нь үзвэл: аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газар 4, Эрүүл мэндийн газар 1, Улсын бүртгэлийн хэлтэс 1 санал, хүсэлтийг хяналтын хуудсаар харьяа байгууллагууддаа шилжүүлж, шийдвэрлэлтийн явцад хяналт тавьж, хариуг иргэнд мэдэгдэж ажилласан байна.

Аймгийн удирдлагуудын долоо хоног бүрийн мягмар гарагт хуралддаг шуурхай хуралдаан 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 11 удаа хуралдаж, Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвд хандаж ирүүлсэн гомдол, мэдэгдэл, санал, хүсэлтийг хэлэлцэж, шийдвэрлэлтэд хариу өгсөн байдалд дүгнэлт хийж, гомдлын мөрөөр авч

хэрэгжүүлэх арга хэмжээ болон эрчимжүүлэх шаардлагатай үүрэг чиглэлийг аймгийн удирдлагын зүгээс тогтмол өгч ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж энэ оны 1 дүгээр улирлын байдлаар 53 иргэний хүсэлтийг биеэр, 1 хүсэлтийг бичгээр ирүүлж нийт 54 хүсэлт бүртгэгдсэн байна. Үүнээс 51 хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг иргэдэд хүргүүлсэн бөгөөд шийдвэрлэх шатанд судлагдаж байгаа 3 хүсэлт байна.

Сумдын Засаг дарга, түүний Тамгын газар, төсөвт байгууллагууд нийт 2483 гомдол, мэдэгдэл, санал, хүсэлтийг хүлээн авснаас 1190 хандалтыг биечлэн, 535 хандалтыг утсаар, 513 хандалтыг цахимаар, 216 хандалтыг албан бичгээр тус тус шийдвэрлэж нийт 2454 гомдол, мэдэгдэл, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа 29 гомдол, мэдэгдэл, хүсэлт байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд нийт 487 санал, гомдол, хүсэлт хүлээн авснаас 298 гомдол, санал, хүсэлтийг биечлэн, 62 гомдол, санал, хүсэлтийг утсаар, 3 гомдол, санал, хүсэлтийг цахимаар, 90 гомдол, санал, хүсэлтийг албан бичгээр тус тус шийдвэрлэж нийт 453 гомдол, мэдэгдэл, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Нийт 6 гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шилжүүлж шийдвэрлэсэн. Үүнээс: хууль хяналтын байгууллагад 1, харьяаллын дагуу байгууллагад 5 гомдол, санал, хүсэлтийг шилжүүлж, шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа 25 гомдол, санал, хүсэлт байна.

Мөн боловсролын байгууллагад иргэдээс ирүүлсэн 3 хүсэлтийг хугацаа хэтрүүлэн (30 хоногт) шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах "11-11" төвөөс шилжиж ирсэн 16 гомдол, санал, хүсэлт ирснийг ажлын 2-5 хоногийн хугацаанд шийдвэрлэж үр дүнг, цахим системд байршуулсан.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН  
ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТӨРӨЛ(ӨВӨРХАНГАЙ АЙМАГ)

Хавсралт-1

№	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2	3	4	5	6	7	8	9
Аймгийн Засаг даргын Тамгын газар				54	53				1
Агентлагийн дүн		33	10	444	343	10	9	11	114
Сумдын дүн	11	69	8	2395	1396	43	627	5	412
Нийт	11	102	18	2893	1792	53	636	16	527

2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН  
ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ (ШИЙДВЭРЛЭЛТ)

Хавсралт-2

Байгууллага	Шийдвэрлэлтийн байдал										Нийт дүн
	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн (30 хоног)	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн (60 хоног)	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй	
	Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
Аймгийн Засаг даргын Тамгын газар	2		12	37	-	-	-	-	3		54
Агентлагийн дүн	90	3	62	298	5	1	3		25		487
Сумдын дүн	216	513	535	1190	-	-	-	-	29		2483
Нийт	308	516	609	1525	5	1	3	-	57	-	3024

2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН  
ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ (АГУУЛГААР)

Хавсралт-3

ӨВӨРХАНГАЙ	№	Өргөдөл, гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
	1	Нийгмийн даатгал, (Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой өргөдөл)	809	26.7	Цаашид мэдэгдэл, гомдол, санал, хүсэлтийг бүрэн цахим (аппликэйшн, Вэб сайт) зэрэгт шилжүүлэн шийдвэрлэлтийн явцыг онлайн болгох.
	2	Нийгмийн халамжийн талаар	688	22.7	
	3	ажилд орохыг хүссэн, ажлаас чөлөөлөгдөх, шилжих зэрэгтэй холбоотой өргөдөл	360	11.9	
	4	Иргэний бүртгэлтэй холбогдолтой	251	8.3	
	5	Газрын асуудлаар	194	6.4	
	6	Шилжилт хөдөлгөөнтэй холбогдолтой	118	3.9	
	7	Материал, мөнгөн тусламж хүссэн	71	2.3	
	8	Бусад төрлийн, (Алдарт эхийн одон, эрчим хүч, тусгай зөвшөөрөл, нийтийн тээвэр,нохой устгал, хог хаягдал, тохирлын үнэлгээ-баталгаажуулалт, татвартай холбоотой гэх мэт)	533	17.6	
9	Нийт	3024	100		

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР